

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР,ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ГАЛИЯ ТАНАА

2023.02.24 № 229
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,860,356.00	2,106,023,906.00
33	АВЛАГА	1,477,860,356.00	2,106,023,906.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,822,000.00	1,944,000.00
335	Бусад авлага	1,474,038,356.00	2,104,079,906.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,477,860,356.00	2,106,023,906.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	1,477,860,356.00	2,106,023,906.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,477,860,356.00	1,477,860,356.00
51220	Тайлант үеийн үр дүн		628,163,550.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	745,775,210.00	1,811,197,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,088,460.00	28,714,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,088,460.00	28,714,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,088,460.00	28,714,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,088,460.00	28,714,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	741,686,750.00	1,782,483,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	726,371,750.00	1,778,483,600.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	726,371,750.00	1,778,483,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,315,000.00	4,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,315,000.00	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	751,896,310.00	1,183,034,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	751,896,310.00	1,183,034,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,782,550.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,048,150.00	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,548,150.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	734,400.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,400.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	744,113,760.00	1,178,534,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	311,313,250.00	615,037,935.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	311,313,250.00	615,037,935.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,088,460.00	28,714,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,088,460.00	28,714,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,681,850.00	176,081,665.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,681,850.00	176,081,665.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	386,030,200.00	358,700,450.00
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	4,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	386,030,200.00	354,700,450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(6,121,100.00)</u>	<u>628,163,550.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(6,121,100.00)</u>	<u>628,163,550.00</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,134,547,410.00	1,815,019,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	392,860,660.00	32,536,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	392,860,660.00	32,536,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,860,660.00	32,536,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	392,860,660.00	28,714,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		3,822,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	741,686,750.00	1,782,483,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	726,371,750.00	1,778,483,600.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	726,371,750.00	1,778,483,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,315,000.00	4,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,315,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,134,547,410.00	2,166,978,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,134,547,410.00	2,166,978,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,782,550.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,048,150.00	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,548,150.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	734,400.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,400.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,125,764,860.00	2,162,478,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	689,142,350.00	1,597,037,935.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	689,142,350.00	1,597,037,935.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,168,460.00	30,658,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,168,460.00	30,658,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,681,850.00	176,081,665.00

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,681,850.00	176,081,665.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	388,772,200.00	358,700,450.00
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		4,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	388,772,200.00	354,700,450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	(351,958,450.00)
14	Бусад эх үүсвэр	-	351,958,450.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		351,958,450.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	351,958,450.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			1,477,860,356.00		1,477,860,356.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,477,860,356.00	0.00	1,477,860,356.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			628,163,550.00		628,163,550.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,106,023,906.00	0.00	2,106,023,906.00

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,780,483,600.00	1,601,537,935.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,780,483,600.00	1,601,537,935.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	4,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,775,983,600.00	1,597,037,935.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,775,983,600.00	1,597,037,935.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,775,983,600.00	1,597,037,935.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,780,483,600.00	1,601,537,935.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,780,483,600.00	1,601,537,935.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,780,483,600.00	1,601,537,935.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2	2
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг зорилтот, бүлэг, хүн амд оновчтой хүргэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайланг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.
 - Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл: Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ногоон ажлын байр хөтөлбөр зэрэг долоон хөтөлбөр 28 төсөл, арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд тус сангийн үйл ажиллагаанд дотоод аудитын чиглэлээр хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын даргын 2019 оны А/289 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 628.2 сая төгрөгөөр буюу 42.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	1,477,860,3	2,106,023,9	628,163.6
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	1,477,860,3	2,106,023,9	628,163.6

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,477,860.3	2,106,023.9	628,163.6

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 628.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн авлага 373.3 сая төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага 29.9 сая төгрөгөөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага 166.8 сая төгрөгөөр, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний авлага 76.9 сая төгрөгөөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага 10.0 сая төгрөгөөр, нэмэгдэж залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн авлага 11.4 сая төгрөгөөр, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төслийн авлага 15.6 сая төгрөгөөр, татаас, санхүүжилтийн авлага 1.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,847.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас шилжүүлгийг 1,777.5 сая төгрөгөөр баталж, урьд оноос 69.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 4.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 28 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,780.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,778.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст төв санд 175.0 сая төгрөгийг төвд төвлөрүүлж, 1.9 сая төгрөгийг Сангийн яамд татсан, батлагдсан төсвөөс 2.0 сая төгрөгийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,601.5 сая төгрөг буюу 89.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	162,556.0	153,624.0	8,932.0	94.5%
2	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	911,885.6	860,400.0	51,485.6	94.4%
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	54,396.0	32,772.8	21,623.2	60.2%

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний дэмжих хөтөлбөр	128,200.0	125,809.1	2,390.9	98.1%
5	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих / эмэгтэйчүүдийг дэмжих болон ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр/	398,106.0	330,580.9	67,525.1	83.0%
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	68,840.0	41,851.1	26,988.9	60.8%
7	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээ	34,000.0	34,000.0	0	100%
8	Ажилд зуучлах арга хэмжээ	18,000.0	18,000.0	0	100%
9	ЗГ-ын зөвлөх хороо, комиссын гишүүдийн зардал	4,500.0	4,500.0	0	100%
	Дүн	1,780,483.6	1,601,537.9	178,945.7	89.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

- 2022 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв өмнөх оноос 2.5 дахин илүү батлагдсанаар төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон түр болон байнгын ажлын байрны тоо 2021 онтой харьцуулахад 2.5 дахин буюу 880-аар нэмэгдсэн байна.
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд зохион байгуулах ажлыг энэ жилийн хувьд зөвхөн Баян-Өлгий аймгаар хязгаарлагдахгүйгээр бусад аймаг, дүүргүүдэд бий болсон ажлын байруудад зуучлах ажлыг гүйцэтгэжээ. Нийт ирүүлсэн 1500 ажлын байрны захиалгаас 650 нь бусад аймаг, дүүргээс ирүүлсэн ажлын байрны захиалга байна. Захиалгын дагуу 812 иргэнийг түр болон байнгын ажилд зуучилсан бөгөөд бусад аймаг, дүүргүүдэд 183 иргэнийг ажилд зуучилсан.
- “ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ” өдөрлөг, арга хэмжээг 8 сумд 9 удаа зохион байгуулж ажилласнаар хөдөө сумдын 5500 гаруй иргэдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэн ажилласан байна.
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад эрүүл, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх, ажиллагсад ажлын байранд эрүүл мэндийн зөв зан үйл, хандлагыг хэвшүүлэн ажиллах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх анхан шатны мэдлэг олгох чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг үе шаттай зохион байгуулж ажилласнаар эрсдэлээс сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахад нөлөөлөн ажилласан байна.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 25-аас дээш ажилтантай 138 аж ахуйн нэгж байгууллагад Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт, шалгалт хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 8 аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага тавьж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 28.7 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. Мөн төрийн байгууллагын 2, хувийн хэвшлийн байгууллагад 4, нийт 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучлан байнгын ажлын байртай болгож хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/31 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 751.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1850.8 сая төгрөгийн 32 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 948.7 сая төгрөгийн 24 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 1134.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас 396.2 сая төгрөгийн 3, бусад мэдээллээс 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	396.2	1	396.2	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	396.2	1	396.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар төсөл, арга хэмжээний зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Байхгүй.

5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн									Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								